



МОНГОЛЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

БАТЛАВ.
ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВИЙН
ДАРГА

..... С.НЯМ-ЭРДЭНЭ

УР ЧАДВАРЫН СОРИЛТ БОЛОН ЛАБОРАТОРИ
ХООРОНДЫН ХАРЬЦУУЛАЛТЫН БОДЛОГО

Боловсруулсан:	Хянаж, өөрчлөлт оруулсан:
Ахлах мэргэжилтэн	Ахлах мэргэжилтэн
З.Мөнхбат	Т.Оюунгэрэл

Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр, В корпус,
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (976) 77073689

Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ.

АГУУЛГА

Sl.	Бүлэг	Хуудас №
	Агуулга	2
1	Хамрах хүрээ	3
2	Бодлого	3
3	Итгэмжлэлийн байгууллага	4
4	Ур чадвар зохион байгуулагч	4
5	Тохирлын үнэлгээний байгууллага	4
	Өөрчлөлтийн хуудас	5

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн №: MNAS AP02	Ур чадварын сорилт, лаборатори хоорондын харьцуулалтын бодлого	
Хэвлэсэн огноо: 2015.03.11	Өөрчлөлт №: 01	
	Өөрчлөлтийн огноо: 2024.04.10	Хуудас: 2/5

УР ЧАДВАРЫН СОРИЛТ БОЛОН ЛАБОРАТОРИ ХООРОНДЫН
ХАРЬЦУУЛАЛТЫН БОДЛОГО

MNAS AP02

1. Хамрах хүрээ

1.1 Энэхүү баримт бичиг нь лабораторийн итгэмжлэлд ур чадварын сорилт (УЧС) болон лаборатори хоорондын харьцуулалт (ЛХХ)-ыг хэрхэн хэрэглэх талаархи MNAS-ийн бодлогыг тодорхойлно. УЧС болон лаборатори хоорондын харьцуулалтад амжилттай үр дүнтэй оролцох нь лабораторийн техникийн ур чадварыг илтгэх бөгөөд MNAS-ийн итгэмжлэлийн үйл ажиллагааны чухал хэсэг болно.

1.2 Бодлогын энэхүү баримт бичигт ILAC-P9:01/2024, Ур чадварын сорилт болон лаборатори хоорондын харьцуулалтад оролцох талаар ILAC-аас баримтлах бодлого баримт бичигт заасан шаардлагыг тусгасан. ILAC-P9-ийн шинэчилсэн найруулгыг ISO/IEC 17025[1], ISO 15189[2] болон ISO/IEC 17011[3]-ын одоогийн хувилбаруудтай нийцүүлэхээр бэлтгэсэн. ISO/IEC 17025:2017 ба ISO 15189:2022 стандартын хүрээнд ур чадварын сорилт (УЧС) болон лаборатори хоорондын харьцуулалт (ЛХХ) дээр тусгай заалтуудыг оруулсан болно.

1.3 Энэхүү баримт бичгийн хүрээнд "Итгэмжлэгдсэн ТҮБ" гэдэг нь сорилт, тохируулгын үйл ажиллагаа явуулдаг бүх ТҮБ-ыг, тухайлбал, сорилт, дээж авах, шалгалт тохируулга, эмнэлгийн лаборатори, хяналтын байгууллага, УЧС-ын хөтөлбөр зохион байгуулагч мөн стандартчилсан загвар үйлдвэрлэгчдийг хэлнэ.

1.4 Энэхүү бодлого нь өмнөх ISO/IEC 17043:2010 стандартаас шинэчлэгдсэн ISO/IEC 17043:2023 Тохирлын үнэлгээ-Ур чадварын сорилтын зохион байгуулагчийн чадавхид тавих ерөнхий шаардлага (PTR) стандартын дагуу итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллагуудыг (ТҮБ) шилжүүлэх үйл явц, MNAS-аар итгэмжлэгдсэн бүх ур чадварын сорилт зохион байгуулагч (PTR) болон өргөдөл гаргагчдад хамаарна.

2 Бодлого

2.1 Үндэсний итгэмжлэлийн төв:

2.1.1 Итгэмжлэлийн байгууллага нь (MNAS) нь Ур чадварын сорилт зохион байгуулагчийн шилжилтийн төлөвлөгөөг шалгана. Үүний дараа шилжилтийн хугацааны туршид Үндэсний итгэмжлэлийн төв (MNAS) нь төлөвлөгөөт итгэмжлэлийн үнэлгээ, магадлах шалгалтыг хийж гүйцэтгэнэ. Хэрэв Ур чадварын сорилт зохион байгуулагч нь шилжилтийг тогтоосон хугацаанаас өмнө хийж дуусгах хүсэлт гаргасан тохиолдолд Итгэмжлэлийн байгууллага (MNAS) нь нэмэлт үнэлгээг хийнэ. Энэхүү шинэчлэгдсэн стандартын шилжилтийн талаарх мэдээллийг ТҮБ-ууд www.mnas.gov.mn вэбсайтаас үзнэ үү.

2.1.2 ILAC P9 баримт бичгийн дагуу MNAS-аас итгэмжлэгдсэн эсхүл итгэмжлүүлэхийг зорьж буй лаборатори нь УЧС-д оролцох төлөвлөгөө (MNAS P703 F02-ийн дагуу)-г албан ёсоор баримтжуулсан байна. Лаборатори нь төлөвлөгөө боловсруулахдаа УЧС-д оролцох лабораторийн хамгийн доод түвшин, давтамжийг тодорхойлж, ажилтан, аргачлал, багаж хэрэгсэл зэрэгт өөрчлөлт орох тохиолдолд төлөвлөгөөгөө тогтмол эргэн шалгадаг байна. Газар дээрх үнэлгээний явцад MNAS-ийн үнэлгээний мэргэжилтнүүд энэхүү төлөвлөгөөг хянан үздэг байна.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AP02	Ур чадварын сорилт, лаборатори хоорондын харьцуулалтын бодлого	
Хэвлэсэн огноо: 2015.03.11	Өөрчлөлт No: 01	Хуудас: 3/5
	Өөрчлөлтийн огноо: 2024.04.10	

2.1.3 ISO/IEC 17025:2017, ISO 15189:2023 стандартын шаардлагыг ханган итгэмжлэгдсэн, эсхүл итгэмжлүүлэхийг зорьж буй лаборатори нь ур чадварын сорилтод хэт хүндрэл учруулахааргүй бол итгэмжлэлийн хүрээнд заасан арга бүрээр хамгийн багадаа итгэмжлэлийн мөчлөгт ур чадварын сорилт болон лаборатори хоорондын харьцуулалтад оролцсон байхыг шаардана.

2.1.4 Хэрэв үр дүн нь “Хязгаараас давсан” гэх ангилалд орсон бол дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг лабораториос шаардана. Үүнд:

- Дотоод аудитаар илэрсэн үл тохирол гэж үзэн өөрийн дотоод механизмыг ашиглан хязгаараас давсан үр дүнгийн шалтгаан, нөхцлийг тодорхойлж, баримтжуулах;
- Хязгаараас давсан утгын шалтгаан, үр нөлөөнд дүн шинжилгээ хийх;
- Хязгаараас давсан утга болон түүний мөрөөр хийсэн дүн шинжилгээг хянах: удирдлагын дүн шинжилгээний хурлын тэмдэглэлээр баримтжуулсан байдлыг шалгах;
- Хязгаараас давсан шалтгаан нь хэрэглэгчид олгосон ямар нэг сорилт буюу шалгалт тохируулгын дүнд нөлөөлсөн эсэх, ямар нөлөө хэр нөлөөлж болох, үр нөлөөг хүлээн зөвшөөрсөн буюу эргүүлэн татах шаардлагатай эсэхийг судлах;
- Илэрсэн зөрүүг шийдвэрлэхийн тулд залруулах арга хэмжээ авах эсхүл лабораторийн үйл явцыг сайжруулахын тулд сэргийлэх арга хэмжээ авах талаар зохих төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;
- Лабораторийн бизнесийн үйл явцыг дэмжих (жишээ нь, сургалт, тоног төхөөрөмж худалдан авах) залруулах, эсхүл сэргийлэх арга хэмжээг хамаарсан аливаа төлөвлөгөөг шууд хэрэгжүүлэхийг лабораториос хатуу шаардах.

2.2 Ур чадвар зохион байгуулагч:

2.2.1 Ур чадварын сорилт зохион байгуулагч нь ISO/IEC 17043:2023 стандартыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн байна.

2.2.2 Ур чадварын сорилт зохион байгуулагч нь үйл ажиллагаандаа дээрх стандартын шинэчилсэн хувилбарыг хэрэгжүүлэх ба ISO/IEC 17043:2023 стандартын Шилжилтийн бодлогыг баримталж ажиллана. Энэхүү шинэчлэгдсэн стандартын “Шилжилтийн бодлого”-ыг www.mnas.gov.mn вэбсайтаас үзнэ үү.

2.3 Тохирлын үнэлгээний байгууллага

2.3.1 Холбогдох ILAC-ын харилцан хүлээн зөвшөөрөх гэрээнд (MRA) гарын үсэг зурах буюу гарын үсэг зурсан статусаа хадгалахыг эрмэлзэж, итгэмжлэгдсэн ТҮБ-ын (жишээ нь, туршилт, тохируулгын үйл ажиллагаа явуулдаг лаборатори эсвэл бусад итгэмжлэгдсэн ТҮБ-үүд) техникийн ур чадвараа тухайн бодлогын хүрээнд хэрэгжүүлэн харуулах ёстой.

2.3.2 ILAC P9 баримт бичгийн дагуу MNAS-аас итгэмжлэгдсэн эсхүл итгэмжлүүлэхийг зорьж буй лаборатори нь УЧС-д оролцох төлөвлөгөө (*MNAS P703 F02*-ийн дагуу)-г албан ёсоор баримтжуулсан байна. Лаборатори нь төлөвлөгөө боловсруулахдаа УЧС, лаборатори хоорондын харьцуулалтад оролцох лабораторийн хамгийн доод түвшин, давтамжийг тодорхойлж, ажилтан, аргачлал, багаж хэрэгсэл зэрэгт өөрчлөлт орох тохиолдолд төлөвлөгөөгөө тогтмол эргэн шалгадаг байна. Газар дээрх үнэлгээний явцад MNAS-ийн үнэлгээний мэргэжилтнүүд энэхүү төлөвлөгөөг хянан үздэг байна. Лаборатори нь УЧС болон лаборатори хоорондын харьцуулалтад хамрагдах төлөвлөгөөг хоёр жилээр төлөвлөсөн байна.

2.3.3 УЧС-оос бусад ЛХХ-д оролцох нь зөвхөн УЧС байхгүй эсвэл тохиромжтой үед л төлөвлөгдөх ёстой гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

2.3.4 Лаборатори нь УЧС-д оролцохоор хүсэлт гаргасан, сорилтын зүйл хүлээн авсан, УЧС-ыг зохион байгуулагчид үр дүнгээ хүргүүлсэн, УЧС-ыг хэрэгжүүлэгчээс албан ёсны тайланг гаргасан талаар MNAS-д мэдээлдэг байна. Нэмэлт болгох тодорхой нарийвчилсан тайлбарт сорилтын төрөл, УЧС-ыг хэрэгжүүлэгчийн мэдээлэл багтсан байна. MNAS-аас олгосон итгэмжлэлийн хүрээнд хамаарахгүй төрлөөр лаборатори нь УЧС-д оролцох бол MNAS-д энэ тухай мэдэгдэх шаардлагагүй.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AP02	Ур чадварын сорилт, лаборатори хоорондын харьцуулалтын бодлого	
Хэвлэсэн огноо: 2015.03.11	Өөрчлөлт No: 01	Хуудас: 4/5
	Өөрчлөлтийн огноо: 2024.04.10	

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

д/д	Өөрчлөлт No.	Хуудас No.	Өөрчлөлт оруулсан шалтгаан
	01	Бүх	Үндэсний Итгэмжлэлийн Төв болж шинэчлэгдэн зохион байгуулагдсантай холбогдуулан мэдээлэл шинэчлэв.
2	02	Бүх	ILAC-P09:01/2024 бодлогын баримт бичиг ийнэчлэгдсэнтэй уялдуулан мэдээлэл шинэчлэв.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AP02	Ур чадварын сорилт, лаборатори хоорондын харьцуулалтын бодлого	
Хэвлэсэн огноо: 2015.03.11	Өөрчлөлт No: 01	Хуудас: 5/5
	Өөрчлөлтийн огноо: 2024.04.10	